XXIII.1.1.1	Цахим мэдээллийн төв, тоног төхөөрөмжийн хамт /Нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрээр баригдах цахим архивтай хамтатган цогцоор шийдвэрлэх/ /Улаанбаатар/	2012	2014	3,299.9	1,410.0
XXIII.1.1.2	Баруун бүсийн хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн ажлын өргөтгөл /Ховд/	2013	2014	1,777.3	273.1
	<i>Шинэ</i>			<i>21,257.0</i>	<i>14,607.8</i>
XXIII.1.1.3	Батсүмбэр асрамж, хөгжлийн үндэсний төвийн нөхөн сэргээх сувиллын барилга /Төв, Батсүмбэр сум/	2014	2015	5,591.1	2,591.1
XXIII.1.1.4	Батсүмбэрийн ахмадын асрамжийн байрын өргөтгөл /Төв, Батсүмбэр сум/	2014	2015	3,398.5	1,699.3
XXIII.1.1.5	Ахмадын ордны барилга /Орхон, Баян-Өндөр сум/	2014	2015	750.0	400.0
XXIII.1.1.6	Ахмадын болон амьдрах ухааны ордон /Завхан, Улиастай сум/	2014	2015	1,200.0	600.0
XXIII.1.1.7	Нийслэлийн нийгмийн даатгалын газар, нийслэлийн нийгмийн халамж, үйлчилгээний газрын барилга, тохижилт, тоног төхөөрөмжийн хамт /Нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрээс хамтран санхүүжүүлнэ/ /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2014	2015	2,000.0	1,000.0
XXIII.1.1.8	Сэргээн засалт үндэсний төвийн нөхөн сэргээх сувиллын барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014	2014	2,190.0	2,190.0
XXIII.1.1.9	Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн барилга, тоног төхөөрөмжийн хамт /Завхан, Улиастай сум/	2014	2014	1,491.0	1,491.0
XXIII.1.1.10	Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн барилга, тоног төхөөрөмжийн хамт /Баянхонгор, Баянхонгор сум/	2014	2014	1,491.0	1,491.0
XXIII.1.1.11	Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн барилга, тоног төхөөрөмжийн хамт /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2014	2014	1,491.0	1,491.0
XXIII.1.1.12	Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн барилга, тоног төхөөрөмжийн хамт /Дархан-Уул, Дархан сум/	2014	2014	1,491.0	1,491.0
XXIII.1.1.13	Иргэдэд үйлчлэх халамжийн төвийн барилгын гадна шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/	2014	2014	163.4	163.4
XXIII.1.3	III.Тонг төхөөрөмж			4,462.0	4,462.0
	<i>Шинэ</i>			<i>4,462.0</i>	<i>4,462.0</i>
XXIII.1.3.1	Сэргээн заслын хөгжлийн үндэсний төвийн протез ортопедийн үйлдвэрийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014	2014	1,800.0	1,800.0
XXIII.1.3.2	Сэргээн засалт үндэсний төвийн автомашины парк шинэчлэл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014	2014	120.0	120.0
XXIII.1.3.3	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын авто машины парк шинэчлэл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2014	2014	200.0	200.0
XXIII.1.3.4	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын салбарын албан хэрэгцээний автомашин	2014	2014	1,500.0	1,500.0
XXIII.1.3.5	Батсүмбэрийн Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвд септик танк /Төв, Батсүмбэр сум/	2014	2014	40.0	40.0
XXIII.1.3.6	Батсүмбэрийн Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвд автобус, трактор /Төв, Батсүмбэр сум/	2014	2014	60.0	60.0
XXIII.1.3.7	Ахмадын асрамж, хөгжлийн үндэсний төвийн эмчилгээний ЗД ЭХО, лаборатори /Төв, Батсүмбэр сум/	2014	2014	42.0	42.0
XXIII.1.3.8	Цахим архивын тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2014	2014	700.0	700.0
XXIII.2	Хүүхдийн төлөө үндэсний газар			11,594.7	7,494.7
XXIII.2.1	I.Хөрөнгө оруулалт			8,871.5	4,771.5

	<i>Шилжих</i>			5,000.0	900.0
XXIII.2.1.1	Усан спорт цогцолбор, 1000 хүн /Улаанбаатар, Найрамдал зуслан/	2013	2015	5,000.0	900.0
	<i>Шинэ</i>			3,871.5	3,871.5
XXIII.2.1.2	Хүүхэд гэр бүл хөгжлийн Өнөрбүл төвийн "Спорт, сургалт үйлдвэрлэлийн төв"- ийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	2014	1,042.9	1,042.9
XXIII.2.1.3	Хүүхэд хөгжлийн төв, хүүхдийн номын сангийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2014	2,500.0	2,500.0
XXIII.2.1.4	Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	2014	328.6	328.6
XXIII.2.2	II.Их засвар			1,529.7	1,529.7
	<i>Шинэ</i>			1,529.7	1,529.7
XXIII.2.2.1	Хүүхдийн хөгжил , хамгааллын төвийн шугам сүлжээний их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	2014	149.9	149.9
XXIII.2.2.2	Хүүхэд гэр бүл хөгжлийн Өнөрбүл төвийн цэцэрлэгийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	2014	180.0	180.0
XXIII.2.2.3	Олон улсын Найрамдал төвийн зам талбайн засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2014	2014	100.0	100.0
XXIII.2.2.4	Олон улсын Найрамдал төвийн дээвэр, цахилгаан, дулааны шугамын системийн засвар /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2014	2014	500.0	500.0
XXIII.2.2.5	Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн барилгын засвар /Дархан-Уул, Дархан сум/	2014	2014	150.3	150.3
XXIII.2.2.6	Улсын асрамжийн "Хараацай" хүүхдийн зуслангийн их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014	2014	200.0	200.0
XXIII.2.2.7	Өвгөн жаргалант хүүхдийн зуслангийн их засвар /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	2014	2014	100.0	100.0
XXIII.2.2.8	Тамир зуслангийн хүүхдийн амрах байрын их засвар /Архангай, Эрдэнэбулган сум/	2014	2014	149.5	149.5
XXIII.2.3	III.Тоног төхөөрөмж			1,193.5	1,193.5
	<i>Шинэ</i>			1,193.5	1,193.5
XXIII.2.3.1	Хүүхэд, гэр бүл хөгжлийн "Өнөрбүл" төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	2014	70.0	70.0
XXIII.2.3.2	Олон улсын Найрамдал төвийн хүүхдийн Хараацай театрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2014	2014	65.0	65.0
XXIII.2.3.3	Тамир зуслангийн хүүхдийн амрах байрын тоног төхөөрөмж /Архангай, Эрдэнэбулган сум/	2014	2014	100.0	100.0
XXIII.2.3.4	Өвгөн жаргалант хүүхдийн зуслангийн тоног төхөөрөмж /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	2014	2014	100.0	100.0
XXIII.2.3.5	Олон улсын Найрамдал төвийн хүүхэд зөөх автобус, ачааны автомашин /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2014	2014	218.5	218.5
XXIII.2.3.6	Хүүхдийн байгууллагуудын автомашины парк шинэчлэл	2014	2014	250.0	250.0
XXIII.2.3.7	Хүүхдийн байгууллагуудын тоног төхөөрөмж	2014	2014	390.0	390.0
XXIV	ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД			293,313.8	132,115.0
XXIV.1	Эрүүл мэнд			222,606.3	106,427.1
XXIV.1.1	I.Хөрөнгө оруулалт			150,834.2	62,370.6
	<i>Шилжих</i>			141,609.0	54,000.4
XXIV.1.1.1	Төрөх эмнэлэг, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2010	2014	13,694.0	5,200.0
XXIV.1.1.2	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн өргөтгөл /Улаанбаатар/	2011	2015	12,780.0	4,781.7
XXIV.1.1.3	Эрүүл мэндийн төвийн барилга, 100 ор, тоног төхөөрөмж, тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2010	2014	7,700.0	2,507.6
XXIV.1.1.4	Төрөх эмнэлэг, 50 ор /Булган, Булган сум/	2011	2014	2,144.3	671.4
XXIV.1.1.5	Эмнэлгийн барилга, 15 ор /Төв, Борнуур сум/	2012	2014	1,084.6	311.0
XXIV.1.1.6	Эмнэлгийн барилга, 15 ор /Өвөрхангай, Нарийнтээл сум/	2012	2014	774.5	232.7
XXIV.1.1.7	Төрөх эмнэлгийн барилга, 50 ор /Дорнод/	2012	2014	2,774.0	1,324.0
XXIV.1.1.8	Төрөх эмнэлгийн барилга, 50 ор /Сүхбаатар/	2012	2014	3,276.3	1,901.3
XXIV.1.1.9	Төрөх эмнэлгийн барилга, 50 ор /Өмнөговь/	2012	2014	3,287.4	1,912.4
XXIV.1.1.10	Эрүүл мэндийг дэмжих төв /Баян-Өлгий/	2012	2014	779.0	79.0
XXIV.1.1.11	Эмнэлгийн амбулаторийн барилга /Булган, Хутаг-Өндөр сум/	2012	2014	879.4	379.4
XXIV.1.1.12	Аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга /Хэнтий/	2012	2015	12,450.9	4,000.0
XXIV.1.1.13	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа "Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-4"	2013	2016	5,100.0	1,200.0
XXIV.1.1.14	Бельгийн Нэгдсэн Вант Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа "Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төвийг сайжруулах" төсөл	2013	2015	8,700.0	1,000.0

XXIV.1.1.15	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /Улаанбаатар/	2013	2015	20,000.0	6,500.0
XXIV.1.1.16	Цус сэлбэлт, судлалын үндэсний төвийн барилга /Улаанбаатар/	2013	2014	2,949.9	1,949.9
XXIV.1.1.17	Эрүүл мэндийг дэмжих төв /Хөвсгөл/	2013	2014	794.9	577.9
XXIV.1.1.18	Сумын эрүүл мэндийн төв, 50 ор /Өмнөговь, Ханбогд сум/	2013	2014	5,419.2	3,219.2
XXIV.1.1.19	Сумын эрүүл мэндийн төв, 50 ор /Өмнөговь, Цогтцэций сум/	2013	2014	5,211.8	4,002.2
XXIV.1.1.20	Говийн бүсийн эмчилгээ, оношилгооны төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	2012	2014	7,247.7	6,267.7
XXIV.1.1.21	Төрөх эмнэлэг, 50 ор /Хөвсгөл, Мөрөн сум/	2013	2014	2,870.1	677.8
XXIV.1.1.22	Эхчүүдийн амрах байрын барилга /Архангай, Төвшрүүлэх сум/	2013	2014	35.0	35.0
XXIV.1.1.23	Эмнэлгийн барилга, 10 ор /Завхан, Асгат сум/	2013	2014	1,014.6	414.6
XXIV.1.1.24	Эмнэлгийн барилга, 10 ор /Дундговь, Адаацаг сум/	2013	2014	861.1	361.1
XXIV.1.1.25	Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2013	2015	618.5	118.5
XXIV.1.1.26	Эмнэлгийн барилга, 10 ор /Архангай, Батцэнгэл сум/	2013	2014	1,132.6	1,047.1
XXIV.1.1.27	Эмнэлгийн барилга, 10 ор /Говь-Алтай, Дэлгэр сум/	2012	2014	736.6	192.2
XXIV.1.1.28	Хөдөөгийн эмнэлгийн ус, ариун цэврийг сайжруулах, аюултай хог хаягдлыг устгах төсөл	2011	2014	450.0	202.2
XXIV.1.1.29	Хүн эмнэлгийн барилга /Архангай, Тариат сум/	2013	2014	1,200.0	334.3
	Дутуу санхүүжилт			15,642.6	2,600.2
XXIV.1.1.30	Төрөх эмнэлэг, 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2013	2014	1,888.8	75.1
XXIV.1.1.31	Сэтгэцийн эмгэг судлалын үндэсний төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2014	4,101.4	901.4
XXIV.1.1.32	Эмнэлгийн барилга, 10 ор /Өвөрхангай, Бүрд сум/	2013	2014	447.8	247.8
XXIV.1.1.33	Эмнэлгийн барилга, 10 ор /Хөвсгөл, Баянзүрх сум/	2013	2014	616.0	136.0
XXIV.1.1.34	Эмнэлгийн барилга, 10 ор /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон/	2013	2014	582.0	122.0
XXIV.1.1.35	Эмнэлгийн барилга, 10 ор /Баянхонгор, Баян-Өндөр сум/	2013	2014	624.7	60.0
XXIV.1.1.36	Эрүүл мэндийг дэмжих төв /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2013	2014	610.1	28.5
XXIV.1.1.37	Эмнэлгийн барилга, 10 ор /Дундговь, Дэлгэрцогт сум/	2013	2014	811.1	311.1
XXIV.1.1.38	Халдвартын эмнэлгийн барилга, 30 ор /Завхан, Улиастай сум/	2013	2014	1,446.0	248.0
XXIV.1.1.39	Эрүүл мэндийг дэмжих төв /Орхон, Баян-Өндөр сум/	2013	2014	820.5	86.5
XXIV.1.1.40	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв /Өвөрхангай, Арвайхээр сум/	2013	2014	1,354.5	64.5
XXIV.1.1.41	Эмнэлгийн барилга, 20 ор /Сүхбаатар, Онгон сум/	2013	2014	616.9	54.9
XXIV.1.1.42	Халдвартын эмнэлгийн барилга, 20 ор /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2013	2014	1,060.5	110.5
XXIV.1.1.43	Эрүүл мэндийн хөтөлбөр, эрүүл мэндийн ажилчдын орон сууц худалдан авах, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн шинэчлэл /Улаанбаатар/	2013	2014	360.9	52.5
XXIV.1.1.44	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн барилгын болон лифтийн засвар	2013	2014	301.4	101.4
	Шинэ			9,225.2	8,370.2
XXIV.1.1.45	Сумын эрүүл мэндийн төв, 20 ор /Хөвсгөл, Их-Уул сум/	2014	2014	850.0	850.0
XXIV.1.1.46	Сумын эрүүл мэндийн төв, 25 ор /Сэлэнгэ, Мандал сум/	2014	2014	2,080.2	2,080.2
XXIV.1.1.47	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн халдвартын эмнэлгийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2014	2014	1,900.0	1,900.0
XXIV.1.1.48	Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Баянхонгор, Шаргалжуут сум/	2014	2014	580.0	580.0
XXIV.1.1.49	Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	2014	2014	600.0	600.0
XXIV.1.1.50	Сувиллын барилга, тоног төхөөрөмжийн шинэчлэл /Дорноговь, Эрдэнэ сум, "Бүрдэнэбулаг" бөөрний сувилал/	2014	2015	1,000.0	500.0
XXIV.1.1.51	Хүүхдийн цусны төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2014	400.0	400.0
XXIV.1.1.52	Эмнэлгийн барилга /Дорнод, Хэрлэн сум, 4 дүгээр баг/	2014	2015	705.0	350.0
XXIV.1.1.53	Эхчүүдийн амрах байрын барилга /Увс, Сагил сум/	2014	2014	110.0	110.0
XXIV.1.1.54	Өрхийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, Энх-Алтай өрхийн эмнэлэг/	2014	2014	450.0	450.0
XXIV.1.1.55	Эрүүл мэндийн төв /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	2014	2014	550.0	550.0
XXIV.1.2	II.Их засвар			15,027.6	14,470.1
	Шинэ			15,027.6	14,470.1
XXIV.1.2.1	Харьяа газрын засвар	2014	2014	4,500.0	4,500.0
XXIV.1.2.2	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар	2014	2014	3,000.0	3,000.0
XXIV.1.2.3	Аймаг, сумын эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар	2014	2014	5,200.0	5,200.0

XXIV.1.2.4	Эмнэлгийн барилгын засвар /Баянхонгор/	2013	2014	148.7	32.0
XXIV.1.2.5	Эмнэлгийн барилгын их засвар /Увс, Хяргас сум/	2014	2014	240.0	240.0
XXIV.1.2.6	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн их засвар	2014	2014	688.9	688.9
XXIV.1.2.7	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн барилгын засвар /Улаанбаатар/	2013	2014	500.0	414.2
XXIV.1.2.8	Эх, хүүхдийн Эрүүл мэндийн үндэсний төвийн барилгын салживч, дээврийн засвар	2013	2014	750.0	395.0
XXIV.1.3	III.Тоног төхөөрөмж			56,703.4	29,545.3
	<i>Шилжих</i>			<i>45,045.1</i>	<i>18,387.0</i>
XXIV.1.3.1	Улсын хоёрдугаар төв эмнэлэг /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2014	3,000.0	1,500.0
XXIV.1.3.2	Улсын гуравдугаар төв эмнэлэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2013	2014	5,500.0	2,500.0
XXIV.1.3.3	Хавдар судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2015	8,000.0	3,000.0
XXIV.1.3.4	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн шим тэжээл, хор судлал, биотехнологийн үндэсний үйлдвэрлэл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2014	2,000.0	1,000.0
XXIV.1.3.5	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2015	7,702.9	1,851.5
XXIV.1.3.6	Нийгмийн эрүүл мэндийн төвүүдийн тохижилт, тоног төхөөрөмж	2013	2014	4,000.0	1,500.0
XXIV.1.3.7	Аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж	2013	2014	2,000.0	1,000.0
XXIV.1.3.8	Эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашин	2013	2014	2,000.0	800.0
XXIV.1.3.9	Зүрх, судасны тусламж үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмж	2013	2014	2,842.2	1,200.0
XXIV.1.3.10	Гемодиализын тусламж үйлчилгээг клиникийн зарим эмнэлгүүд, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд шинээр байгуулах	2013	2014	1,500.0	800.0
XXIV.1.3.11	Ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ, үйлчилгээний тусламж үйлчилгээг сайжруулах	2013	2014	3,500.0	1,500.0
XXIV.1.3.12	Эмнэлгүүдийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийг тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2013	2014	2,300.0	1,500.0
XXIV.1.3.13	Арьсны өвчин судлалын үндэсний төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2013	2014	700.0	235.5
	<i>Шинэ</i>			<i>11,658.3</i>	<i>11,158.3</i>
XXIV.1.3.14	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014	2014	1,000.0	1,000.0
XXIV.1.3.15	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохиргооны төхөөрөмж /Улаанбаатар/	2014	2014	500.0	500.0
XXIV.1.3.16	Удамзүйн лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014	2014	1,300.0	1,300.0
XXIV.1.3.17	Оношилгооны төвийн тоног төхөөрөмж /Аймгуудад/	2014	2014	3,214.3	3,214.3
XXIV.1.3.18	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмж /Дорнод, Хэрлэн сум/	2014	2014	360.0	360.0
XXIV.1.3.19	Аймгуудын Эрүүл мэндийн газрын түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, засвар /Дархан-Уул, сумд; Сэлэнгэ, Баянгол сум/	2014	2015	1,000.0	500.0
XXIV.1.3.20	Дүүргийн эмнэлгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2014	2014	2,300.0	2,300.0
XXIV.1.3.21	Амаржих газруудад эх барихын яаралтай, нярайн нэн шаардлагатай тоног төхөөрөмж /Аймаг/	2014	2014	1,200.0	1,200.0
XXIV.1.3.22	Үргүйдлийн тусламж үйлчилгээг сайжруулах, эвсэл үр шилжүүлэн суулгах лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2014	2014	420.0	420.0
XXIV.1.3.23	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ	2014	2014	364.0	364.0
XXIII.1.4	IV.Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл			41.1	41.1
XXIII.1.4.1	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн харьяа түлэнхийн төвийн барилгын зураг төсөв	2013	2014	41.1	41.1
XXIV.2	Спорт			70,707.5	25,687.9
XXIV.2.1	I.Хөрөнгө оруулалт			67,243.5	23,297.5
	<i>Шилжих</i>			<i>47,242.5</i>	<i>11,847.5</i>
XXIV.2.1.1	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2010	2015	9,019.9	3,010.0
XXIV.2.1.2	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2010	2015	8,229.3	2,742.2
XXIV.2.1.3	Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2010	2015	10,397.9	2,260.0
XXIV.2.1.4	Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2008	2014	2,288.0	1,080.0
XXIV.2.1.5	Спорт цогцолборын барилга /Завхан, Улиастай сум/	2012	2015	2,800.0	1,400.0

XXIV.2.1.6	Спорт цогцолборын барилга /Дорноговь, Хатанбулаг сум/	2013	2014	913.4	537.9
XXIV.2.1.7	Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сум/	2011	2014	11,041.0	328.0
XXIV.2.1.8	Спорт цогцолбор /Ховд, Манхан сум/	2012	2014	600.0	37.0
XXIV.2.1.9	Спорт заалын барилга /Дорнод, Хэрлэн, 2 дугаар баг/	2012	2014	453.0	12.4
XXIV.2.1.10	Хүүхэд залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейны байгуулах /Архангай/	2013	2014	1,500.0	440.0
	<i>Шинэ</i>			<i>20,001.0</i>	<i>11,450.0</i>
XXIV.2.1.11	Спорт цогцолборын барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2015	6,378.0	2,000.0
XXIV.2.1.12	Спорт цогцолбор, усан бассейны барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	2014	2014	900.0	900.0
XXIV.2.1.13	Спортын ордны барилга /Өвөрхангай, Хархорин сум/	2014	2015	4,400.0	2,200.0
XXIV.2.1.14	Баруун бүсийн тамирчдын бэлтгэлийн төв /Завхан, Улиастай сум/	2014	2014	4,200.0	4,200.0
XXIV.2.1.15	Усан бассейны барилга /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2014	2015	3,973.0	2,000.0
XXIV.2.1.16	Спорт, эрүүл мэндийн чийрэгжүүлэлтийн төв /Дорнод, Хэрлэн сум, 9 дүгээр баг/	2014	2014	150.0	150.0
XXIV.2.2	II.Их засвар			2,814.0	2,228.4
	<i>Шинэ</i>			<i>2,814.0</i>	<i>2,228.4</i>
XXIV.2.2.1	Спортын салбарын их засвар	2014	2014	2,120.0	2,120.0
XXIV.2.2.2	Спортын салбарын их засвар	2013	2014	694.0	108.4
XXIV.2.3	III.Тоног төхөөрөмж:			650.0	162.0
XXIV.2.3.1	Спортын салбарын тоног төхөөрөмж	2013	2014	650.0	162.0
XXV	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА			495.7	495.6
XXV.4	IV.Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл	2013	2014	495.7	495.6
XXVI	АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙД			1,500.0	1,500.0
XXVI.1	Чөлөөт бүс			1,500.0	1,500.0
XXVI.1.1	I.Хөрөнгө оруулалт			1,500.0	1,500.0
	<i>Шилжих</i>			<i>1,500.0</i>	<i>1,500.0</i>
XXVI.1.1.1	"Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийн албан хаагчдын орон сууц худалдан авах, 30 айл /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2014	2014	1,500.0	1,500.0
	НИЙТ ДҮН			3,327,977.4	1,180,947.9

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ,
ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2014 ОНЫ 10 ДУГААР САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

1.1. Макро эдийн засгийн гүйцэтгэл¹

Эдийн засгийн өсөлт: ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2014 оны эхний 9 сард 11093.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 7.0 хувиар өслөө. Үүнд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 15.4 хувь, аж үйлдвэр, барилгын салбарынх 15.3 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. ДНБ-ий 7.0 хувийн өсөлтийн 5.0 пунктийг уул уурхай, олборлох салбар, 1.8 пунктийг хөдөө аж ахуйн салбар, 1.8 пунктийг үйлчилгээний бусад салбар хангасан байна. Уул уурхай, олборлох салбарын хувьд зэсийн баяжмалын олборлолт 38.0 хувь, алтных 10.9 хувь, газрын тос 50.2 хувь, төмрийн хүдрийн баяжмал 2.1 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөллөө. ДНБ, оны үнээр 2014 оны эхний 9 сард 16517.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 18.8 хувиар өслөө.

Гадаад худалдаа: Монгол Улс 2014 оны эхний 10 сард гадаад худалдааны нийт бараа эргэлт 9,080.0 сая ам.доллар, үүнээс экспорт 4,605.7 сая ам.доллар, импорт 4,474.3 сая ам.доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 258.8 сая ам.доллар буюу 2.9 хувь, экспортын хэмжээ 1125.5 сая ам.доллар буюу 32.3 хувиар өсч, харин импортын хэмжээ 866.7 сая ам.доллар буюу 16.2 хувиар буурчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2013 оны эхний 10 сард 1.9 тэрбум ам.долларын алдагдалтай гарч байсан бол 2014 оны эхний 10 сард 131.4 сая ам.долларын ашигтай гарлаа. Экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 1125.5 сая ам.доллар буюу 32.3 хувиар нэмэгдэхэд зэсийн баяжмалын экспорт 1183.2 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлөв.

Импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 866.7 сая ам.доллар буюу 16.2 хувиар буурахад импортын дүнд өндөр хувийн жин эзэлдэг авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт 381.5 сая ам.доллар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 334.8 сая ам.доллар, эрдэс бүтээгдэхүүнийх 158.7 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлөв.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 2014 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.8 хувь, оны эхнээс 9.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 12.1 хувиар өссөн байна.

1.2. Нэгдсэн төсвийн 2014 оны 11 дүгээр сарын гүйцэтгэл

Төсвийн орлогын гүйцэтгэл: Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2014 оны 11 дүгээр сарын гүйцэтгэлээр 5,267.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 16.2 хувиар буюу 1,019.1 тэрбум төгрөгөөр дутуу биелж, өмнөх оны мөн үеийнхээс 6.2 хувиар буюу 306.6 тэрбум төгрөгөөр илүү байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого татварын орлогоор 85.9 хувь, татварын бус орлогоор 14.1 хувь тус тус бүрдсэн үзүүлэлттэй байна.

Улсын төсөвт 2014 оны эхний 11 сард 3,536.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, жилийн төлөвлөгөөний 75.3 хувь нь биелээд байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 136.4 тэрбум төгрөг буюу 4.0 хувиар өссөн байна. Төсвийн тогтворжуулалтын санд 47.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж нийт хуримтлал 430.2 тэрбум төгрөг болсон байна.

¹ Үндэсний Статистикын хороо, 2014 оны 10 дугаар сарын бюллетень

Татварын ерөнхий газар энэ оны эхний 11 сарын байдлаар улсын төсөвт 1,389.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь жилийн төлөвлөгөөний 67.0 хувьтай тэнцэж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 2 хувиар буюу 24.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Харин Гаалийн ерөнхий газар улсын төсөвт 1,425.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь жилийн төлөвлөгөөний 74.2 хувьтай тэнцэж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 3 хувиар буюу 41.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Монгол Улсын 2014 оны төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс буурахад экспортын гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний үнэ болон биет хэмжээ буурсан, ам.доллараар хэмжигдэх нийт импортын хэмжээ багассан болон дотоодын эдийн засгийн өсөлтийн хурд саарсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Уул уурхайн голлох бүтээгдэхүүн нүүрс, төмрийн хүдэр, жоншны үнэ, экспортын биет хэмжээ 2014 оны төлөвлөсөн хэмжээнээс 30-40 орчим хувиар буурчээ. Тухайлбал, 2014 онд 31.4 сая тонн нүүрсийг тонн тутамд бүтээгдэхүүний чанараас хамааруулан 119.8-64.5 ам.доллараар экспортлохоор төлөвлөсөн боловч хүлээгдэж буй гүйцэтгэлээр 17.0 сая гаруй тонныг 70-22 ам.долларын үнээр экспортлох төлөвтэй байна. Мөн, 7.8 сая тонн төмрийн хүдрийг тонн тутамд 115-106 ам.доллараар экспортлохоор төсөвт тусгасан бол оны эцэст 5.5 сая орчим тонныг 90-80 орчим ам.доллараар экспортлох хандлагатай байна.

Уул уурхайн голлох бүтээгдэхүүний экспортын бууралт нь уул уурхайн компаниудын ашигт ажиллагаа, санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлж, улмаар төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс буурахад нөлөөлөөд зогсохгүй уул уурхайн салбарт бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ нийлүүлдэг бусад байгууллагуудын үйл ажиллагаа, ашигт сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсын Эрдэнэсийн сан, гадаад активын нөөцийг нэмэгдүүлэх, алтны салбарт ил тод байдлыг бүрдүүлэх зорилгоор 2014 оны 1 дүгээр сард УИХ-аас баталсан алтны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг 2.5 болгон бууруулахаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Уг хуулийн нөлөөгөөр Монголбанканд тушаагдаж буй алтны хэмжээ 50 орчим хувиар, татвар ногдож буй алтны хэмжээ 10 орчим хувиар нэмэгдсэн эерэг үр дүн гарсан байна. Гэхдээ биет хэмжээний өсөлт нь татвар хөнгөлснөөс төсөвт учирч буй татварын орлогын бууралтыг нөхөх хэмжээнд хараахан хүрээгүй байна.

Улсын Их Хурал, Засгийн газраас 2014 онд эдийн засгийн өсөлтийг 11.7 хувьд хүрнэ гэж тооцсон боловч хүлээгдэж буй гүйцэтгэлээр 7 хувь болж өсөлт саарч байна. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш энэ онд дунджаар 1,810 болж суларсан байна. Түүнчлэн, банкны системийн хэмжээгээр хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 281.1 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 8.2 хувиар өссөн нь аж ахуйн нэгжийн төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж, зардал өсөх шалтгаан болж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтаас хамаарсан тоног төхөөрөмж, хүнд машин, механизмын импорт буурсан, валютын ханш, инфляцын өсөлтөөс шалтгаалан дотоодын хэрэглээ хумигдаж байгаа нь нийт импорт буурах үндсэн нөхцөл болсон байна.

Үүнээс үүдэн импорт, тэр дундаа татвартай импортоос хамаарч улсын төсөвт төвлөрөх орлогууд төлөвлөсөн хэмжээнд хүрэхээргүй байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэл: Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2014 оны 11 дүгээр сарын байдлаар 6,623.4 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 5,708.3 тэрбум төгрөгийн буюу 86.2 хувийн, улсын төсвийн зарлага 4,737.6 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 4,119.0 тэрбум төгрөгийн буюу 86.9 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Улсын Их хурлын 2014 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн “Эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 34 дүгээр тогтоол, Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолын дагуу бүх шатны төсөвт байгууллагууд төсөв хэмнэх, шинээр орон тоо нэмэгдүүлэхгүй, чиг үүргийн давхардлыг арилган, үр ашиггүй зардлыг хэмнэх улмаар зарим нэр төрлийн зардлуудыг тодорхой хувиар бууруулан **хэмнэлтийн горимд шилжин ажиллаж байна.**

Төсвийн орлогын бүрдэлт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байгаа хэдий ч цалин хөлс, нийгмийн даатгал, халамж, ашиглалтын тогтмол, эм хоол, гадаад зээлийн үйлчилгээний төлбөр зэрэг байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн зардлуудыг цаг тухайд нь бүрэн олгож байна. Бусад төрлийн зардлуудын санхүүжилтийг мөнгөн хөрөнгийн зохицуулалтын хүрээнд хэсэгчлэн олгох зарчим баримталж байна.

Орон нутгийн төсвийн зарлага 1,775.4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 81.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгаас улсын төсөвт 51.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна. Улсын төсвөөс орон нутагт 2014 оны эхний 11 сард олгохоор төлөвлөж байсан 816.2 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 133.4 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн олгоод байна.

Хүний хөгжил сангийн зарлага 268.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 98.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас хүүхдэд олгож байгаа бэлэн мөнгөний санхүүжилтээр 220.0 тэрбум төгрөгийг олгоод байна.

Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 100.3 хувийн буюу 1,180.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас улсын эмнэлгүүдэд 113.7 тэрбум төгрөгийн татаас олгосон байна.

Төсвийн тэнцэл: 2014 оны 11 дүгээр сарын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 755.0 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 440.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 48.2 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 582.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

2. ТӨСВИЙН ТОДОТГОЛ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1. Төсөвт тодотгол хийх үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан. Засгийн газрын бүтцийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт орох өөрчлөлт болон төсвийн хэрэгжилтийн явцад үүссэн шаардлагатай бусад зохицуулалтыг тусгах зорилгоор Төсвийн тухай хуулийн 34.1.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд тодотголын төслийг боловсруулна гэж заасныг үндэслэн Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулаад байна.

2.2. Төсөвт тодотгол хийхэд баримталсан зарчим

Монгол Улсын 2014 оны төсвийн тодотголыг боловсруулахдаа дараах зарчмыг баримтлав. Үүнд:

1. Засгийн газрын бүтцийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор холбогдох өөрчлөлтийг тусгах;

2. 2013 оны төсвийн жилд батлагдсан боловч тухайн жилдээ санхүүжигдэж чадаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн векселийн төлбөрт шаардагдах хөрөнгийг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөвт нэмж тусгах;
3. 2014 онд ашиглах боломжгүй хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил, зураг төсөл боловсруулах ажлын зардлыг бууруулан тооцох;
4. Төрийн албан хаагчдын цалинг 2014 онд салбарын онцлог, инфляцын түвшинтэй уялдуулан ялгавартай, үе шаттай нэмэгдүүлж байгаатай холбогдон Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөвт зохих өөрчлөлтийг тусгах;
5. Орон нутгийн төсвийн орлогод зайлшгүй шаардлагатай зарим өөрчлөлтийг тусгах;
6. Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцаас хэмнэх боломжтой зарим арга хэмжээний зардлыг бууруулан тооцох;
7. Хүний хөгжил сангийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор шинээр үнэт цаас гаргах эрхийг нэмэгдүүлэх;

3. ТӨСВИЙН ТОДОТГОЛООР ХИЙГДЭХ ӨӨРЧЛӨЛТҮҮД

3.1. Нэгдсэн төсвийн 2014 оны урсгал зардлын тодотголын тухай

Засгийн газрын бүтцийн өөрчлөлт, төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсөвт тусгах, зохицуулалт хийх, зарим арга хэмжээний зардлыг бууруулахаар 2014 оны төсвийн тодотголын төсөлд тусгалаа.

Засгийн газрын бүтцийн өөрчлөлт: Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүдийг УИХ-ын нэгдсэн чуулганаар 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдөр баталсантай холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтын дагуу зохих өөрчлөлтийн нөлөөллийг 2014 оны төсвийн тодотголын төсөлд тусгав.

Дээрх шийдвэрүүдийн дагуу нийт 1,241 орон тоо бүтцийн өөрчлөлтөд хамрагдаж байгаа бөгөөд 1,130 орон тоо шинэ бүтцийн дагуу ажиллахаар болж, 111 төрийн албан хаагчийн орон тоог бууруулахаар тооцлоо. Төсвийн тодотгол хийх хугацаатай уялдуулан зөвхөн 12 дугаар сарын дүнгээр холбогдох тооцоог хийсэн бөгөөд нийт 477.1 сая төгрөг хэмнэгдэж байна. Харин татан буугдах, өөрчлөн зохион байгуулалтаар нэгдэж буй яамдын сайдын ажлын алба, төрийн захиргаа, удирдлагын газар, гадаад хамтын ажиллагаа, хууль, хяналт шинжилгээ, үнэлгээ зэрэг нийтлэг чиг үүргийн нэгжүүдийг нэгтгэн зохион байгуулсны үр дүнд ажлаас чөлөөлөгдөж байгаа 111 албан хаагчид 795.3 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг олгохоор байна. Бүтцийн өөрчлөлтийн орон тоо, төсвийн судалгааг дор харуулав.

Хүснэгт. Засгийн газрын бүтцийн өөрчлөлтийн төсвийн нөлөөлөл

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, байгууллагууд	2014		2014 ТОД төсөл		Бүтцийн өөрчлөлт нөлөөлөл		
		орон тоо	Урсгал зардал	орон тоо	Урсгал зардал	орон тоо	Урсгал зардал	Тэтгэмж
1	Ерөнхий сайд	104	315.9	54	372.0	-50	-128.3	184.5
2	Эдийн засгийн хөгжлийн сайд	129	1,985.8			-129	-1,985.8	
3	Соёл, спорт, аялал жуучлалын сайд		216.4			-80	-216.4	

		80						
4	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	143	227.4	-	58.5	-143	-227.4	58.5
5	Хүнс, хөдөө аж ахуйн сайд /хуучин ҮХААС/	138	29,575.9	115	29,562.3	-23	-13.6	
6	Хөдөлмөрийн сайд	125	4,184.9	110	4,176.0	-15	-8.9	0.0
7	Шадар сайд	-	0.0	36	32.1	36	32.1	
8	Сангийн сайд	145	9,366.8	311	11,706.0	166	1,806.0	533.2
9	Аж үйлдвэрийн сайд	-	0.0	80	251.0	80	251.0	
10	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд	71	2,294.7	110	2,330.4	39	35.7	
11	Эрүүл мэнд, спортын сайд	118	2,480.8	85	2,423.9	-33	-56.9	
12	Байгаль орчин, аялал зуучлалын сайд	110	2,031.0	120	2,041.1	10	10.2	
13	Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалалын сайд	78	24,876.5	82	24,899.3	4	3.7	19.1
14	Монгол Улсын сайд			6	6.1	6	6.1	
15	Орон нутгийн засаг захиргаа			21	15.4	21	15.4	
	НИЙТ ДҮН	1,241	77,556.0	1,130	77,874.3	-111	-477.1	795.3

Цалингийн нэмэгдэлтэй холбоотой өөрчлөлт: Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт цалинг инфляцын түвшин, бүтээмж, салбарын онцлогийг харгалзан ялгавартайгаар, мөн тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшнийг харгалзан нэмэгдүүлэхээр туссан бөгөөд цалин, тэтгэврийн хэмжээг өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөхгүйн тулд нийтэд зарлахгүйгээр салбар бүрээр нэмэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлаас 2014 оны төсөвт цалин, тэтгэврийн нэмэгдэлд нийт 200.0 тэрбум төгрөг анх баталсан бол хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт хэлэлцээрээр нэмж тохиролцсоны дагуу төсвийн тодотголоор 35 тэрбум төгрөгийг зөвхөн цалинг нэмэгдүүлэх зориулалтаар нэмж тусгасан.

Засгийн газраас цалин хөлсийг нэмэгдүүлэхдээ салбар бүрийн онцлогийг харгалзан үзэж, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбар болон бусад салбарын үйлдвэрчний эвлэлийн байгууллага, ажил олгогч эздийн холбоо зэрэг байгууллагатай хэлэлцэн, зөвшилцсөний үндсэн дээр цалин нэмэгдүүлэх тухай Засгийн газрын 2014 оны 75, 208, 332 дугаар тогтоолыг тус тус батлан төрийн албан хаагчдын цалинг ялгавартай, үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Цалин нэмэгдүүлэх шийдвэрийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийгдэх шаардлага үүсэж нийт 32.9 тэрбум төгрөгийн зардал шаардагдаж байгаа бөгөөд энэ дүн нь 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдөр УИХ-аас баталсан төсвийн тодотголд туссан 35.0 тэрбум төгрөгт багтаж байна.

Зарим арга хэмжээний зардлын бууралт: Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцаас хэмнэх боломжтой нийт 51.0 тэрбум төгрөгийн арга хэмжээ, зардлыг бууруулан тооцлоо.

Хүснэгт. Бууруулж буй зарим арга хэмжээний зардал

#	Арга хэмжээ	Мөнгөн дүн /сая төг/
1	Арьс ширний татаас	12,972.8

2	Өр барагдуулах зардал	13,500.0
3	Суралцагсдад олгох амьжиргааны тэтгэлэг /МСҮТ/	1,500.8
4	Нийгмийн халамжийн зардал	2,500.0
5	Байгаль хамгаалах нөхөн сэргээх	1,300.0
6	Боловсролын төвлөрсөн арга хэмжээ - ном	1,270.9
7	Боловсролын төвлөрсөн арга хэмжээ - хичээл үйлдвэрлэлийн дадлага	500.0
8	Зарим байгууллагын цалингийн сангийн зардал	1,651.2
9	Цэвэр агаар сан	5,000.0
10	Бүх нийтийн үүргийн сангийн татаас	500.0
11	Соёл, урлаг хөгжүүлэх сан	500.0
12	Эрүүл мэндийг дэмжих сан	300.0
13	Гадаад, дотоод томилолт, зочин төлөөлөгч, эд хогшил	2,555.5
14	Төвлөрсөн арга хэмжээ болон бусад зардал	6,971.0
	Нийт дүн	51,022.1

Зарим арга хэмжээний зарлагын өсөлт: Нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог 117.6 мянган хүнээр тооцож, нийтийн тээврийн нөхөн олговрын зардлыг 6.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэв.

Татварын ерөнхий газрын өөрийн үйл ажиллагааны орлого болох НӨАТ-ын падаан, онцгой албан татварын тэмдэг, бусад үнэт цаасны маягтын орлого 1,450.0 сая төгрөгөөр нэмэгдсэнээр зарлага нь өсөх тооцоо хийлээ.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлийн эргэн төлөлтэй холбогдуулан тус сангийн дотоод эх үүсвэрээс олгох зээлийг 25.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр 2014 оны тодотголын төсөлд тусгалаа.

Зээл, бондын үйлчилгээний төлбөр: Монгол Улсын 2014 оны төсөвт гадаад валютаар илэрхийлэгдэх зээл, бондын үйлчилгээний төлбөрийг валютын ханшийн өөрчлөлттэй холбоотойгоор дахин тооцох шаардлага үүсэж байна. Гадаад валютаар хийгддэг дараах төлбөрүүдийн нийт 60.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсвийн тодотголд зайлшгүй нэмж тусгах шаардлагатай байна.

Хүснэгт. Зээл, бондын үйлчилгээний төлбөрт нэмж шаардагдах хэмжээ

№		2014 төлөвлөгөө /сая төгрөг/	2014 тодотгол төсөл /сая төгрөг/	Зөрүү /сая төгрөг/
1	Чингис бондын гадаад хүүгийн төлбөр	103,048.9	133,736.4	30,687.5
2	Гадаад зээлийн хүүгийн төлбөр	40,121.4	45,478.9	5,357.5
3	Хөгжлийн банкны бондын хүүгийн төлбөр	41,663.2	65,916.3	24,253.1
	Нийт	184,833.5	245,131.6	60,298.1

Түүнчлэн Засгийн газрын дотоод бондын хүүгийн төлбөр жилийн эцэст 171.9 тэрбум төгрөгт хүрэхээр байгаа нь батлагдсан төсөвтэй харьцуулахад 21.1 тэрбум төгрөгөөр бага байхаар байна. Иймээс Улсын төсвийн зээл, бондын үйлчилгээний дүнг 60.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх болон дотоод бондын хүүгийн төлбөрийг 21.1 тэрбум төгрөгөөр бууруулж, нийтдээ 39.2 тэрбум төгрөгөөр төсвийн зардлыг нэмэгдүүлэхээр тооцлоо.

Мөн Үндэсний Аудитын газрын 1/53 тоот албан шаардлагын дагуу Монголбанкаас ОУВС-гийн бүртгэлийг шилжүүлсэнтэй холбоотой төлбөрийн зөрүү болох 148.5 сая төгрөгийн зардлыг төсвийн тодотголын төсөлд тусгалаа.

Гадаад зээлийн ашиглалт: Гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжих төслүүдийн 2014 оны ашиглалтыг дахин тооцоход нийтдээ 30.0 тэрбум төгрөгөөр гадаад зээлийн ашиглалт буурахаар байгааг төсвийн тодотголын төсөлд тооцон тусгалаа.

3.2. Төсвийн орлогын тодотголын тухай

Чингис бондын хүүгийн орлого: Чингис бондын нийт хөрөнгийг Монгол Улсын Хөгжлийн банканд байршуулсны хүүгийн орлого болох 30.8 тэрбум төгрөгийг Улсын төсвийн хүүгийн орлогод тусган тооцлоо. Мөн Төрийн сангийн хадгаламжийн хүүгийн 5.4 тэрбум төгрөгийн орлогыг төсвийн тодотголын төсөлд тусгалаа.

Орон нутгийн төсвийн орлого: Орон нутгийн 2014 оны төсвийн нийт орлого ба тусламжийн дүн оны эхний 11 сарын байдлаар 1,838.2 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөсөн хэмжээнээс 5 орчим хувиар дутуу гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлийг төлөвлөсөн хэмжээтэй харьцуулахад нийт дүнгээрээ харьцангуй бага зөрүүтэй байхаар байгаа боловч тогтоол шийдвэрүүдийн өөрчлөлттэй холбогдуулан зарим аймгуудад зарим орлогын нэр төрлөөр төсвийн төлөвлөгөөг зайлшгүй тодотгох нь зүйтэй гэж үзэж дараах орлогыг бууруулахаар тооцлоо. Үүнд:

1. Хувь хүний орлогын албан татварын орлого: Хувь хүний орлогын албан татварын орлого эхний 10 сарын байдлаар төлөвлөсөн хэмжээнээс 7.6 хувиар дутуу төвлөрсөн байна. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 332 дугаар тогтоол батлагдаж цалингийн дундаж хэмжээг 10-15 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь энэ оны үлдэх хугацаанд хувь хүний орлогын албан татварын орлогын тасралтыг тодорхой хэмжээнд нөхөхөөр байгаа боловч нийт дүнгээрээ 530 орчим сая төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс буурахаар байна.

2. Усны нөөц ашигласны төлбөрийн орлого: Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын ихэнхийг бүрдүүлдэг “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Оюу толгой” ХХК зэрэг томоохон байгууллагууд хэрэглэсэн усыг дахин ашиглах замаар зохистой хэрэглээнд шилжиж, хэмнэлт гаргаж хэрэглээгээ эрс бууруулаад байна. Мөн дахин ашигласан усны төлбөрийг хуулийн дагуу чөлөөлж байгаа нь усны нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөсөн хэмжээнээс тасрахад ихээхэн нөлөөлж байна.

Түүнчлэн 2014 оны батлагдсан төсөвт усны нөөц ашигласны төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолуудыг үндэслэн тооцож тусгасан боловч усны төлбөр ногдох хувь хэмжээг Засгийн газраас шинэчлэн тогтоож, усны ашиглалтыг тооцох итгэлцүүрийг бууруулсан байна.

Иймд шинээр батлагдсан Засгийн газрын тогтоолуудыг баримтлан байгуулсан ус ашиглах гэрээний дагуу Булган аймгийн усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2.2 тэрбум төгрөгөөр, Өмнөговь аймгийн усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 19.2 тэрбум төгрөгөөр тус тус бууруулан төсвийн тодотголын төсөлд тусгалаа.

3. Төсөвт байгууллагын өөрийн орлого: Татварын ерөнхий газрын өөрийн үйл ажиллагааны орлого болох НӨАТ-ын падаан, онцгой албан татварын тэмдэг, бусад үнэт цаасны маягтын орлогыг 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тусгалаа.

3.3. Улсын төсвийн 2014 оны хөрөнгө оруулалтын тодотголын тухай

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд тусгагдаж эх үүсвэр нь батлагдсан боловч нийт 95.2 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэлийг төсвийн орлогын бүрдэлтээс шалтгаалан 2013 оны төсвийн жилд санхүүжүүлж чадаагүй юм. Тиймээс Засгийн газрын 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 26 дугаар тогтоолын дагуу 268 аж ахуйн нэгжийн хийж гүйцэтгэсэн 191 төсөл, арга хэмжээний 95.3 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг Сангийн яам вексель бичиж өгөх замаар баталгаажуулж, Төрийн банкаар дамжуулан тэдгээрийг мөнгөжүүлсэн билээ.

Иймд 2014 оны төсвийн тодотголд Төрийн банкнаас мөнгөжүүлсэн векселийн төлбөрт шаардагдах хөрөнгийг нэмж тусган, холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагчдаар дамжуулан Төрийн банканд буцаан олгохоор төлөвлөлөө.

Эдийн засгийн хөгжлийн сайдын /хуучин нэрээр/ 2014 оны төсвийн багцад “Монгол Улсын хэмжээнд 2015-2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил, зураг төсөл боловсруулах” төсөлд нийт 42.9 тэрбум төгрөгийн эх үүсвэр батлагдсан. Энэхүү эх үүсвэрээс 2013 онд хийгдсэн боловч энэ онд магадлалын ерөнхий дүгнэлт гарч хүлээн авсан зураг төсвийн ажлын 11.4 тэрбум, түүнчлэн 2014 онд гэрээ байгуулагдаж ажил нь эхэлсэн нэг маягийн зураг, төсвийн ажлын үлдэгдэл 2.5 тэрбум төгрөгийг тус тус төсөвт үлдээж, үлдэх 29.0 тэрбум төгрөгийг ашиглах боломжгүй гэж үзлээ.

Эрчим хүчний сайдын /хуучин нэрээр/ 2014 оны төсвийн багцад батлагдсан “Аймгийн төвүүдэд шинээр дулааны станц, дулааны шугам барих /Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Төв, Архангай, Говь-Алтай, Дундговь, Хэнтий, Булган/” төслийг Засгийн газрын 2014 оны 29 дүгээр тогтоолоор “Төр, хувийн хэвшлийн түншлэл”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тул 21.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг бууруулж, төсвийн тодотголд тусгалаа.

3.4. Орон нутгийн 2014 оны санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн төлөвлөгөөнд тодотгол хийх тухай

Орон нутгийн суурь орлого нийт 21.9 тэрбум төгрөг буурсан болон цалингийн өөрчлөлт, засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор орон нутагт олгох санхүүгийн дэмжлэг 2.5 тэрбум төгрөгөөр өсөж, 161.1 тэрбум төгрөг байхаар төсвийн тодотголын төсөлд тусгалаа.

Дээрх өөрчлөлтүүдтэй холбоотойгоор үндсэн тэнцлийн ашигтай аймгуудын орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх дүн 19.0 тэрбум төгрөгөөр буурч 265.8 тэрбум төгрөг болж байна.

Боловсролын сайдын багц дахь Улаанбаатар хотын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого 0.5 тэрбум төгрөгөөр нэмэгдлээ. Мөн цалингийн өөрчлөлт болон сургууль, цэцэрлэгийн зарим урсгал зардлын зохицуулалттай холбоотойгоор орон нутагт олгох тусгай зориулалтын шилжүүлэг 1.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

3.5. Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсөвт тодотгол хийх тухай

Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуулиар сангийн орлогыг 1,249.5 тэрбум төгрөгөөр баталсныг 1,249.6 тэрбум төгрөгөөр, сангийн зарлагыг 1,289.2

тэрбум төгрөгөөр баталсныг 21.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 1,310.3 тэрбум төгрөгөөр төсвийн тодотголд тусгаж байна.

Улсын Их Хурлаас 2014 оны 12 дугаар сарын 04-ны өдөр Засгийн газрын бүтцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбоотойгоор төсвийн зарим байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн орлого өөрчлөгдөж байна.

Нийгмийн даатгалын сангийн эхний 10 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тэтгэвэр, тэтгэмжид хамрагдаж буй иргэдийн тооны өсөлттэй холбоотойгоор нийгмийн даатгалын сангийн зардлыг 21.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолын дагуу үйл ажиллагааны зардлыг 0.1 тэрбум төгрөгөөр бууруулж, нийт цэвэр дүнгээр 21.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж байна. Үүнд:

Тэтгэврийн даатгалын сан: “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулиар ажилласан хугацаа, Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор тэтгэвэр нь өөрчлөгдсөн иргэдийн тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн, мөн тэтгэвэр авагчдын тоо 8.2 мянган хүнээр нэмэгдсэнээс тэтгэврийн болон ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага төлөвлөж байснаас 20.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сангийн 2014 оны 11 дугаар сарын мэдээнээс үзэхэд тэтгэврийн даатгалын сангаас 329.3 мянган тэтгэвэр авагчдад 899.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон байна.

Тэтгэмжийн зардал: Жирэмсэн амаржсаны тэтгэмжид 2014 оны эхний 11 сард 41.0 мянган даатгуулагчид 51.7 тэрбум төгрөг олгосон нь 2014 оны батлагдсан төсвөөс 6.1 тэрбум төгрөгөөр илүү буюу 113 хувийн гүйцэтгэлтэй байна. Сүүлийн жилүүдэд хүүхэд төрүүлж буй эхчүүдийн тоо нэмэгдэж байгаагаас жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжид хамрагдаж буй эхчүүдийн тоо 5.8 мянган хүнээр нэмэгдсэн тул тэтгэмжийн даатгалын сангийн зардлыг 6.6 тэрбум төгрөгөөр өсөж байна.

Ажилгүйдлийн тэтгэмж: Ажилгүйдлийн даатгалын сангаас 2014 оны 11 дугаар сард 13.2 мянган даатгуулагчид 16.2 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон нь 2014 оны батлагдсан төсвийн 111 хувийг зарцуулсан байна. Иймд тус сангийн зардлыг 1.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сан: Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал нийт 7.9 тэрбум төгрөгөөр хэмнэгдэхээр байна. Зарим хувийн эмнэлэг, рашаан сувиллын магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан, шалгаруулалтад тэнцээгүй тул 3.0 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийг урамшуулах журам боловсруулах, эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулах ажил хойшлогдож 2014 оны 9 дүгээр сарын 1-ээс урамшуулалд хамрагдах нөхцөлийг бүрдүүлсэнтэй холбоотойгоор 6.0 тэрбум төгрөг зардлыг бууруулж, харин эмийн үнийн хөнгөлөлтийн зардлыг 1.0 тэрбум төгрөгөөр өсгөж байна.

Хүснэгт. Нийгмийн даатгалын сангийн зардлын өөрчлөлт /сая төгрөг/

Сангийн төрөл	2014 оны батлагдсан	2014 оны тодотгосон	Зөрүү
1. Тэтгэврийн даатгал	949 294.4	973 867,3	+24 572.9
2. Тэтгэмжийн даатгал	66 611.5	73 255,5	+6 644.0
3. ҮОМШӨ-ний даатгал	35 241.4	31 571.4	-3 670.0
4. Ажилгүйдлийн даатгал	15 242.0	16 907.5	+1 665.5

5. ЭМ-ийн даатгал	189 184.8	181 196.6	-7 988.2
6. Ажиллагааны зардал	20 041.4	19 965.2	-76.1
7. Бусад	13 548.2	13 548.2	-
НИЙТ	1 289 163.8	1 310 311.8	+21 148.0

Мөн Нийгмийн даатгалын сангийн хуримтлалын сангаас Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 200.0 тэрбум төгрөг байхаар төсвийн тодотголын төсөлд тусгалаа.

3.6. Хүний хөгжил сангийн 2014 оны төсөвт тодотгол хийх тухай

Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн зарлага, санхүүжилтийг гүйцэтгэхэд гаргасан Засгийн газрын бондын эргэн төлөлт оны эцэст хийгдэх болон Оюу толгой ХК-ны хямдруулсан үнэт цаасны эргэн төлөлттэй холбоотойгоор тус сантай холбоотой зарлага, санхүүжилтийг бүрэн хийхийн тулд 320.0 тэрбум төгрөгийн үнэт цаас гаргаж, эх үүсвэр төвлөрүүлэх шаардлага үүсэж байна.

-о О о-

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмсүгэй:

"6 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн хуримтлалын сангаас Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 200,000.0 сая төгрөгөөр баталсугай."

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1.	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	
1.1	Тэтгэврийн даатгалын сан	973,867.3
1.2	Тэтгэмжийн даатгалын сан	73,255.5
1.3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	31,571.4
1.4	Ажилгүйдлийн даатгалын сан	16,907.5
1.5	Эрүүл мэндийн даатгалын сан	181,196.6
1.6	Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны төлбөр	118.9
1.7	Үйл ажиллагааны урсгал зардал	19,965.2
1.8	Хөрөнгийн зардал	13,429.3
	Нийт зарлага	1,310,311.8

"

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн

"Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд 1,249,512.0" гэснийг "Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд

